

ИРГЭН УЛСЫН ҮЕИЙН ЗҮҮН МОНГОЛЫН ЗОХИОЛЧДЫН ХЭВЛЭЛИЙН  
ҮЙЛСЭД ОРУУЛСАН ГАВЬЯА ЗҮТГЭЛИЙН ТУХАЙ ӨГҮҮЛЭХ НЬ

Баягууд Яруу \*

\* БНХАУ, Өвөр Монголын их сургууль болон АНУ-ын Индианагийн их сургуулийн хамтарсан хөтөлбөрийн докторант

**Түлхүүр үг:** иргэн улс, Зүүн Монголын зохиолчид, хэвлэлийн үйлс, соёлын шилжилт, сэхээтний бүлэг, Монгол утгын сургаалын хурал

**Агуулгын товч:**

**З**үүн Монгол гэдэг нь Хорчин, Зостын чуулган ба Харчин монголыг багтаасан Өвөр Монголын зүүн хэсэг юм. Иргэн Улсын үед Зүүн Монголд Ролгоржав, Хээшингэ, Бөххишиг нараар төлөөлүүлсэн нэг бүлэг зохиолчдоор бүрэлдсэн дэвшилт сэхээтнүүдийн бүлэг бүрэлдсэн байна. Тэд мэдлэгийн соёлыг дамжуулагч төдийгүй, бас хэвлэлийн эдүгээчлэлийг хэрэгжүүлэгч байсан юм. Зүүн Монголын зохиолчид нь судлаач, хэвлэн нийтлэгч, сурган хүмүүжүүлэгчийн хувиар нийгмийн ажиллагааг өрнүүлж, эрдэм шинжилгээний хэв загварын бүрэлдэл, хэвлэлийн үйлсийн дэвшил ба үндэстний сурган хүмүүжлийн өөрчлөлт шинэчлэлд маш чухал нөлөө үзүүлсэн байна.

“Зүүн Монгол” гэдэг нь газар зүйн болон нийгмийн бүлэг цогцын тухай ойлголт юм. Иргэн Улсын үеийн Зүүн

Монгол нь хорчин, зост ба харчин монголыг багтаасан Өвөр Монголын зүүн хэсгийг заана. ХХ зууны эхээр, Жиримийн чуулганы Хорчин зүүн гарын Өмнөд хошууны Хээшингэ, Зуу одын чуулганы найман хошууны Бөххишиг, Жиримийн чуулганы Хүрээ хошууны Ренчинхарлав, Зостын чуулганы Харчин хошууны Эрдэмтөгс, Зуу одын чуулганы Хишигтэн хошууны Эрдэнэ-тогтох нар утга зохиолын тавцанд гарч, тэд нарын соён гэгээрүүлэх утга зохиолоороо монгол үндэстний ойр үеийн утга зохиолын хөшгийг нээж ирсэн байна. Ролгоржавын “Хэрээний дуу”, “Нон мөрөн”, “Алтан ороонго цэцэг”, Хээшингийн “Дөрвөн цагийн чармайлт”, “Тариачныг нигүүлсэх дуу”, “Монголын ван гүн”, Бөххишигийн “Япон улсын сургуулийг тойрон үзсэн өдөр бүрийн тэмдэглэл”, Буяндэлгэрийн “Малын хүмүүн”, “Монгол хүмүүн буянаар”, “Дөрвөн цагийн амьсгал”, Ренчинхорлоогийн “Гашууны дотор тэлчлэгч хэмээх үлгэр”, Эрдэмтөгсийн “Хаврын сураг”, “Хаврын өглөө”, “Хаврын цэцэг”, Эрдэнэтогтохын “Шинэ шүлгийн үг”, “Шүлгийн үг”, “Морины цол”, “Хөх Монголын хүүхдийн суртал”,

“Монгол угсаатан мэдтүгэй” зэрэг бүтээл нь тухайн үеийн монгол зохиолчдын уран бүтээлийн хамгийн дээд түвшнийг төлөөлж, цаг үеийн мэргэдийн өндөр үнэлэлтийг авсан байна.

Зүүн монголын зохиолчид нь судлаач, хэвлэн нийтлэгч, сурган хүмүүжүүлэгч зэрэг олон нийгмийн гаралтай. Тэд нар бүлгэм хурлын садан байгуулж, бичгийн хороо эрхлэн, сургууль байгуулж, эдгээр нийгмийн гарлаараа нийгмийн ажиллагааг өрнүүлэн, монгол үндэстний хэвлэлийн үйлсийн хөгжил дэвшлийг түргэтгэсэн юм.

**М**онгол үндэстний хэвлэлийн үйлс нь XIV зуунаас эхлэн соёолж, ХҮII, XVIII зуун гэхэд зохих хэмжээний хөгжлийн түвшинд хүрчээ. XVI зуунаас эхлэн сүм хийд нь монгол хэвлэлийн төв болж, бурхан шашин нь монголын нийгмийн үзэл санааны хүрээ царыг ноёрхжээ. XX зууны эхний үеийн соёлыг эзэмшсэн сэхээтнүүдийн эгнээний бүрэлдэл, хэвлэлийн мэргэжлийн шинэчлэлт, соёл мэдлэгийн түгээмэлжил нь монгол үндэстний хэвлэлийн үйлсийн эдүгээчлэлийг ахиулав. Сүм хийдийн хэвлэлийн үйлсийн хүрээн дэх ганцаар эзэмшлийг эцэслүүлж, олон төрөл шинжийн шинэ хэлбэрийн хэвлэлийн үйлсийг хөгжүүлсэн нь энэ цаг үеийн монгол хэвлэлийн үйлсийн нэгэн онцлог цаг үе болсон юм. Энэ хөгжилтийн явцад Зүүн монголын зохиолчид гарамгай үйлдэл үзүүлж, хэвлэлийн үйлсийн ахиц шинэчлэлтийг уриалан дагуулагч төдийгүй биелүүлэгч нь болсон юм.

### **Нэг. Сэхээтнүүдийн бүлэг байгуулагдсан нь**

Иргэн Улсын үеийн Зүүн монголын сэхээтнүүдийн бүлэг цогцын бүрэлдэл нь тухайн үеийн нийгмийн хувьсал өөрчлөлттэй шууд холбоотой байжээ. Ном бичиг туурвих, найруулах, хэвлэхээр дамжин соёлын мэдлэгийг түгээж, соёлыг дэлгэрүүлэх хүсэл зорилгоо биелүүлэх нь тэд нарын хамтын хөөцөлдөл байсан юм. Иргэн Улсын үед Зүүн монголын маш олон зохиолч нь найруулагч байсан бөгөөд зарим нь насан туршид найруулагчийн ажилд махран зүтгэжээ. Хээшингэ, Ролгоржав, Бөххишиг, Эрдэнэтогтох, Манижав нар нь цөм энэхүү зохиолчдын эгнээнд багтана. Эдгээр зохиолчид нь нэр алдар болон хүчир бэрхэд тайван хандаж, найруулагчийн ажилд хүчин зүтгэж, монгол хэвлэлийн үйлсийн хагжил дэвшилд гавьяа зүтгэл гаргажээ.

1926 онд Хээшингэ, Ролгоржав нар мөнгө цуглуулан, Мүгдэнд (Одоогийн Лионин мужийн төв Шэнян хот) Зүүн монголын бичгийн хороог үүсгэн байгуулж, монгол бага сургуулийн сурах бичиг, түүх соёл болон уран зохиолтой холбоотой ном бичгийг хэвлэн тараажээ. 1922 онд Хээшингэ Дундад Иргэн Улсын Улсын хурлын Доод зөвлөлийн гишүүнээр сонгогдов. 1923 онд Цао Күн гэдэг цэргийн эрхтэн ерөнхийлөгчийн тушаалд өрсөлдөж, Хээшингийг аргадан татсанд тэрээр зөвлөлийн гишүүний албан тушаалыг тэр даруй орхиж ханцуй сэжин оджээ. 1932 онд Японы түрэмгийлэгчдээс Манж улсын Хянган баруун мужийн Ардын явдлын танхимийн

дараагийн албан тушаалаар аргадан татахад Хээшингэ мөн л хатуу үгээр давшжээ. Тэр бүхий л анхаарал хүчээ монгол үндэстний хэвлэлийн үйлсэд төвлөрүүлэхийг хичээж байв. 1936 онд Хээшингэ Бөххишгийн урилгаар Монгол утгын сургалын хурлын зөвлөгчөөр ажиллав. 1940 онд Вангийн сүмд (одоогийн Улаан хот) монгол үсгээр Зохион орчуулах хүрээг үүсгэн байгуулж, “Монгол утгын нөхвөр бичиг” хэмээх сурах бичгийг найруулан туурвижээ. Эдгээр үйл хэрэг нь Хээшингийн найруулах үйлсэд хандах халуун урам сэтгэлгээг илрүүлсэн бөгөөд бас найруулах хэвлэх ажлаар дамжиж үндэстний соёлоо хөгжүүлэн мандуулах гэсэн эрч хүч, зоригийг нь илтгэв.

Ролгоржав 1917 онд гүн хэргэмээр өргөмжлөгдөж, 1922 онд Мүгдэнд Жан Шюй Лионингийн цэргийн яаманд зөвлөгчөөр ажиллаж, 1927 онд Хишигтэн хошуунд буцаж засаг ноён суусан бөгөөд 1932 онд Манж улсын Хянган баруун мужийн дарга болж, насан туршид хэргэм зэргийг эдлэж явжээ. Гэтэл тэр гол хүчин чадлаа найруулах ажилд шавхав. Зүүн монголын бичгийн хороог байгуулсны дараа, эзэгнэн хамааралтад бүх хүчээ зориулснаар барахгүй, бас бүх сэтгэл зүрхээрээ сурах бичгийг найруулах ажилд оролцож, эцэст “Анхан сургах улсын утга”-ыг (нийт 8 дэвтэр) найруулах ажлыг биелүүлэв. Манж улсын Хянган баруун мужийн дараагийн тушаалд байхдаа Монгол утгын сургалын хурлын удирдах багшаар уригдаж, том хэмжээний толь бичиг найруулах ажлыг эхлүүлжээ. Тухайн үед тэр ингэж зэрэг хэргэм нэмэгдэн дэгжин мандаж

байхад харин бусдын бодлогоос гадуур “Хачин үйл” бясалгаж байсан нь маш гайхууштай байсан бөгөөд өөрөө ч бусад хүнд “Мужийн дараагийн зэрэг хэргэм гэдэг чинь хий хоосон нэр төдий, найруулж бичих ажил бол сая миний чухал үйл мөн” гэж хэлж байжээ. Эдгээр үйл хэргээс түүний амь насны хөөцөлдөл бол ноён тушаал зэрэг хэргэм биш, харин үндэстний соёлыг түгээмэлжүүлэх болон дэлгэрүүлэн хөгжүүлэх үйл мөн гэдгийг мэдэж болно.

**Б**өххишиг бол Монгол утгын сургаалын хурлыг үүсгэн байгуулагч бөгөөд бас голлон найруулах ажилд оролцогч мөн. Монгол утгын сургаалын хурал Кейлуд шилжсэний дараа Бөххишигээс сэтгүүл найруулах болон ном бичиг хэвлэх ажилд хүчээ төвлөрүүлжээ. “Улаан барс” сэтгүүлийн “Тус хурлын худалдаж бүхий бичиг хараа”-д тэмдэглэснийг үндэслэвэл, 1935-1944 оны хооронд, Монгол утгын сургаалын хурал нь 40 гаруй төрлийн ном бичгийг хэвлэж, үүний доторх 20 гаруй төрлийн ном бичгийг Бөххишиг өөрөө төсөвлөн найруулж, оршил бичжээ. “Монголын язгуурын түүх”-ийг хэвлэх үед Бөххишиг: “Англи, Франц, Герман, жич Оросын зэрэг олон улсад цөм тус тусын утгаар орчуулан авсан дэвтэр бий амой. Дайн атал монгол утгын уг дэвтэр нь манай Монголдоо их чухаг болж, шууд эрж олдохгүй болсон”<sup>1</sup> гэж харамсан өгүүлжээ. Хятад хэлнээс “Монголын нууц товчоо”-ыг орчуулах үед тэр бас: “Ертөнц дахины монголын түүхийг сүвэгчилж нягтлагч бүхэн цөм мөнхүү бичгээр гол үндэс болгож аваачихын тулд, улс бүр цөм түүний

хэлэн дээрээ орчуулан аваад шүүмжилж байхад харин манай Монголдоо өдгөө болтол монголчлон авсан дэвтэр үгүй байна. Энийг харин ч ухааран ойлгохгүй мэт, өөрийн дээдсийн чухал түүхээ ч мэдэхийг хичээхгүйгээр бодохноо бусад аймагт улиран шингээгдэж угсаагаар мөхөх зовлон тулагдвой гэж хэлж хэнд гомдомуй<sup>2</sup> хэмээн шүүрс алдан өгүүлжээ. Ингэж “шүүрс алдах” учрыг дахин үүсгэхгүйн тулд Бөххишиг халшралгүйгээр үндэстний соёлоо хөгжүүлэн уламжлах аргыг сүвэгчилжээ.

**Э**рдэнэтогтох, Манижав нар бол алдарт шүлэгч бөгөөд шинэ Дундад Улсын монгол сонины үйлсийн суурилагчид юм. 1943 онд Бөххишиг нас барсны дараа Эрдэнэтогтох “Улаан барс” сэтгүүлийн гол найруулагчийн үүргийг залгамжилж, сэтгүүлийн тусгай булангийн талаар их өөрчлөлт хийв. 1944 оны арав дахь дугаараас эхлэн “Улаан барс” сэтгүүл нь “Эрүүлийг хамгаалах”, “Утга уянга”, “Инээдэм үг”, “Эрдэмтний шастир”, “Монгол үлгэр”, “Байлдааны ухаан” зэрэг тусгай булан нэмж, агуулга нь нэн ерөнхийлсөн шинжтэй болжээ. Шинэ Дундад Улс байгуулагдсаны дараа Эрдэнэтогтох урьд өмнө “Өвөр Монголын өдрийн сонин”-ы хороо, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, Өвөр Монголын түүх, хэл, утга зохиол судлах газар, Өвөр монголын монгол хэл бичгийн ажлын зөвлөл зэрэг байгууллагын удирдах албыг хариуцав. Манижав Өвөр монголын хүрээ хошууны Сугчин гацаанд мэндэлж, долоон насандаа хувийн сургуульд сууж, арван зургаан насандаа Вангийн сүм (одоогийн Улаан

хот) дэх Хянгэн дээд сургуульд шалгуулан дэвшжээ. 1941 оны эхэнд “Хөх туг” сэтгүүлийн хороонд очиж найруулан орчуулах ажлыг хийв. 1945 оны 6 сард “Хөх туг” сэтгүүлийн хорооны ажлаа орхиж, Вангийн сүмд очиж өөртөө засах хөдөлгөөнд оролцов. Шинэ Дундад Улс байгуулагдсаны дараа Манижав “Өвөр Монголын өдрийн сонин”-ы найруулагчаар ажиллаж, монгол сонингийн үйлсэд томоохон их хувь нэмэр оруулжээ.

### **Хоёр. Хэвлэлийн мэргэжлийн шинэчлэлт**

Хорголжин барын үүсэл бол хэвлэлийн түүхэн дэх чухал нэгэн шинэчлэлт юм. Хорголжиноор нэр сийлэх түвэгтэй ажлыг хөнгөвчилж, дахин давтан хэрэглэх боломжтой бол угаасаа соёлыг шуурхай дамжуулахад маш том дэвшил гаргасан юм. XX зууны эхний үеэр монголчууд хорголжин барын хэвлэлийн мэргэжлийг эзэмшиж, хоёр иж хорголжин үсгийн хэвийг цутгасан юм. Даруй 1919 онд тэмдэгтийн үүссэн хорголжин үсэг болон 1927 онд Хээшингийн цутгасан хорголжин үсэг болно. Хээ мэргэний зохиосон “Хээшингэ нэгэн хорчин монгол хүмүүн” гэх номд, Хээшингийн хорголжин үсгийг цутгасан үйл явдлыг ингэж тэмдэглэв: “Тэр сэтгэл зориг гарган, аливаа хэрэг учраас зайлан, өнгөрсөн цаг үеийн “Монгол үсгийн цагаан толгойн хүснэгт”-ийг судалжээ. Тэрээр 29 монгол үсгийн цагаан толгойг өдөржин шөнөжин судалж, хүч тамираа шавхан, хэчнээн удаа жагсааж, дахин тохируулалт хийсны эцэст сая хамгийн зохистой дэс

дарааллаар жагсааж, шинэ “Монгол үсгийн цагаан толгойн хүснэгт”-ийг зохиож гаргав. Энэхүү “Монгол үсгийн цагаан толгойн хүснэгт”-ийг анх эхлэхдээ тэр зөвхөн хорголжин үсэг цутгаж ном бичиг хэвлэхэд зориулж байсан бол хожим нь харин санаанаас гадуур монгол үндэстний соёлын хөгжилтийн явц дунд урт хугацаанд үргэлжлэн хэрэглэгдснээр барахгүй дутагдах юм бол үсэггүй нэг зүйлийн оюун ухааны өв хөрөнгө болсон билээ. Шинэ “Монгол үсгийн цагаан толгойн хүснэгт” мэндэлсний дараа удалгүй түүний Бээжингийн найз Дэмгэдтэй хамтран гуравдугаар тиг, тавдугаар дэгийн монгол хорголжин үсэг, хожим хүмүүсийн нэрлэсэн Зүүн монголын хорголжин үсэг нь Мүгдэнд мэндэлжээ. Хоёр иж монгол хорголжин үсгийн мэндэлсэн нь монгол хэвлэлийн үйлсийг хөгжлийн нэгэн шинэ шатанд гаргажээ”<sup>3</sup>. 1936 онд Хээшингэ Монгол утгын сургалын хуралд зөвлөгчөөр уригдаж, тэрээр “Зүүн монголын хорголжин үсэг”-ийг багтаасан бүх хэвлэлийн тоног төхөөрөмжийг Монгол утгын сургалын хуралд бэлэглэн өгчээ.

### **Гурав. Мэдлэгийн соёлыг түгээн дэлгэрүүлсэн нь**

Иргэнчилсэн хэвлэгдхүүн бол Зүүн монголын зохиолчдын мэдлэгийн соёлыг дамжуулах гол хэрэгсэл болно. Тэд нар сонин, сэтгүүл болон ном бичиг зэрэг хэрэгслийг ашиглан мэдлэгийн соёлыг дамжуулж, монгол ардыг гэгээрүүлэх зорилгодоо хүрчээ.

Сонин сэтгүүл найруулах чиглэлээр Зүүн монголын зохиолчид урьд өмнө “Монгол хошуунд тархаах арван

өдрийн дармал”, “Улаан барс”, “Их хөх туг” зэрэг сонин сэтгүүлийг үүсгэн эрхэлэв. 1924 оны 9 сард үүсгэн байгуулсан “Монгол хошуунд тараах арван өдрийн дармал” бол Иргэн Улсын зүүн хойтох засгийн хэргийг эрхлэх Вэй Юан Хойн Монгол хошууны хэргийг шийтгэх яамны байгууллагын сэтгүүл юм.

**Т**ус сэтгүүлийг Хээшингэ орчуулах хянах ажлыг хариуцаж, Зүүн монголын бичгийн хороогоос хэвлэж, голдуу эл яамын байгууллага, эл хошуу болон сургуульд хүргэдэг. Агуулгын хувьд голдуу хорооны өгүүлэл, улсын дотно гаднах сонин мэдээ, шүүмжлэлт зохиол, тусгай нийтлэл, албан бичиг, байцаалт болон дагалдуулал гарчигтай байдаг”<sup>4</sup>. “Улаан барс” бол Монгол утгын сургалын хурлын байгууллагын сэтгүүл юм. Тус сэтгүүл нь Бөххишиг, Эрдэнэ-тогтох, Ролгоржав болон Хээшингэ зэрэг зохиолчдын хөдөлмөр хөлсийг шингээсэн байдаг. “Улаан барс” нь 1927 онд үүсч, 1944 онд хэвлэл зогсох болтол нийт арван дугаар гарчээ. “Улаан барс” сэтгүүлийн нэр нь монголын түүхтэй нягт холбоотой бөгөөд гүн зузаан түүхийн агуулагатай байдаг. Энэ тухай “Улаан барс” сэтгүүлийн арав дахь дугаарын нэг, хоёрдугаар нийлмэл тэмдэгт нийтлэгдсэн “Улаан барс”-ын тайлбарт: “Энэ дарамлалыг яахан улаан барс хэмээсэн ажээ, тэр нь суут Богд Чингис хаан улаан барс жилийн (1206) арван хоёр сарын нэгэнд өдгөөгөөс долоон зуун гучин жилийн өмнө, Онон мөрний хөвөөнд есөн хөлт цагаан тугийг босгон, хаан суудлыг эзэгнэсэн тул энэ оноор өнө үүрдийн дурсгал болгон

түүний арван хоёрдугаар жарны улаан барс жилд эл хурлыг үүсгэн байгуулж сарын дармалын нэрийг улаан барс хэмээсэн болой”<sup>5</sup> гэж тайлбарласан байдаг. “Улаан барс” сэтгүүл нь эхний үедээ нэг хувь “Хурлын үйл ажиллагааны мэдээллийг цуглуулан нийлүүлж” нийтэлдэг сэтгүүл байж, хожим хурлын ажлын урагштай болохыг дагалдан ерөнхийлсөн шинжтэй сэтгүүл болж, агуулга болон хэлбэрийн хувьд маш их шинэчлэгджээ.

“Их хөх туг” сэтгүүлийг 1943 оны нэгдүгээр сард Уулын монголын хурлын гэрийн “Монгол шинэ сэтгүүл”-ийн суурин дээр үүсгэн байгуулж, Манижав найруулах ажлыг хариуцжээ. “Их хөх туг” нь ерөнхийлсөн шинжтэй сэтгүүлд юм. Агуулгын хувьд голдуу улс төрийн шүүмж, орчуулсан бүтээл, байлдааны мэдээ, шинжлэх ухааны мэдлэг, амьдралын ерийн мэдлэг, төрөгдөл, үлгэр, зүйр цэцэн үг, шүлэг дуулал, шог үлгэр, хүүхдийн асуулт хариулт болон шог зураг зэрэг бий. Найруулагч нь угсаа үндэстний соёлыг хөгжүүлэх халуун сэтгэлгээтэй монгол үндэстний сэхээтэн байсан учраас уг сэтгүүл нь танин мэдэхүйн болон соён сэгээрүүлэх шинжийг бүрдүүлсэн онцлогтой”<sup>6</sup>.

Ном бичиг найруулах хувьд, иргэнчилсэн ном бичиг болон сурах бичиг бол Зүүн монголын зохиолчдын ном бичиг найруулах ажлын гол чиглэл байсан юм. Сүм хийдийн барлалын монгол соёл дахь нөлөөгийн бууралт болон монгол хэвлэлийн үйлсийн эдүгээжилтийн ахицыг түргэтэхийг дагалдан, Иргэн Улсын үеийн монгол ном бичгийн сэдэв сонголт нь үндсэндээ шашин суртахууны судар

бичгээс иргэнчилсэн ном бичиг болон сурах бичиг тийш шилжжээ. Тухайн үед монгол утгын сургаалын хурал нь эртний ном судрыг хэвлэхээр дамжин, монгол ардын түүхэн дурдатгалыг хөндөхөөр чармайж, дээдсийн бахархалт түүхээр битүү мунхаг монголчуудын нийгмийг дуудан сэрээхээр оролдож, урьд өмнө “Монголын нууц товчоо”, “Монголын язгуурын түүх”, “Хөх монголын хөх туг” болон “Чингисийн үеийн түүх” зэрэг түүхийн нэрт бүтээлийг хэвлэжээ.

Бас монгол үндэстний алдарт зохиолч Инжиннашийн “Хөх монголын хөх судар”, “Нэгэн давхар асар”, “Улаанаа ухилах тэнхим” зэрэг зохиол бүтээлийг цуглуулан хэвлэж, монгол үндэстний одоо үеийн утга зохиолын сан хөмрөгт ховор чухаг эд хөрөнгийг хурамтлуулжээ. Зүүн монголын бичгийн хорооноос “Анхан сургах улсын утга”-ыг хэвлэж, монгол сурах бичиг байхгүй хоосон зайг нөхжээ. “Анхан сургах улсын утга”-ыг Ролгорзав найруулан бичиж, Хээшингэ засалт хийж, 1927-1929 оны хооронд Зүүн монголын бичгийн хороо хэвлэжээ. Засан найруулсан “Анхан сургах улсын утга” нь нийт зургаан дэвтэр бөгөөд хэвлэн тараасны дараа сурган хүмүүжил болон эрдэм шинжилгээний мэргэжилтнүүдийн маш сайн үнэлэлтийг хүртжээ. “Анхан сургах улсын утга” нь хэвлэгдсэний дараа Монгол орны “Оюун түлхүүр хэмээх бичиг”, “Чингис богдын сан”, “Сэн Зи Жин судар”, “Мин Сянь Жи бичиг” зэрэг эртний ном судраар заах материал болгож байсан уламжлалыг эвджээ. Үүний зэрэгцээ цаг үеийн шинж, шинжлэх ухаанч шинж, дэвшилт шинжийг агуулсан

өөртөө найруулах бага сургуулийн сурах бичгийн шинэ цагийг нээв. Энэ бол Монгол үндэстний сурган хүмүүжлийн түүхэн дэх урьд гараагүй шинэ үзэгдэл мөн. “Анхан сургах улсын утга” бол Монгол орны сурган хүмүүжлийн үйлсийн хүрээн дэх нэгэн гэрэл цацарсан туг бөгөөд дэвшилт үзэл санааг түгээхэд онцгой чухал нөлөө үзүүлжээ<sup>7</sup>.

#### Ишлэл

1. *Бөххишиг*. Монголын язгуурын түүх, Оршил. Кайлу: Монгол утгын сургаалын хурал, 1941, х.1.
2. *Бөххишиг*. Монголын нууц товчоо, Оршил. Кайлу: Монгол утгын сургаалын хурал, 1941, х.1.
3. *Хээ Мэргэн, Хээшингэ*. Нэгэн хорчин монгол хүмүүн. Хөх хот: Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. 2001, х.32-33.
4. Түймэр улс байгуулагдахаас өмнөх Өвөр Монголын газар орны сонин сэтгүүлийг магадалсан гарчиг. Өвөр монголын номын сан. 1987, х.16.
5. “Улаан барс” сэтгүүлийн мэдэгдэл. Улаан барс, 1944. №4.
6. Түймэр улс байгуулагдахаас өмнөх Өвөр монголын газар орны сонин сэтгүүлийг магадалсан гарчиг. Өвөр монголын өөртөө засах орны номын сан. 1987. х.20.
7. *Се.Доржийн зохиолын түүвэр*. Хөххот: Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2001, х.348.

#### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Бөххишиг*. Монголын язгуурын түүх, Оршил. Кайлу: Монгол утгын сургаалын хурал.
2. *Бөххишиг*. Монголын нууц товчоо, Оршил. Кайлу: Монгол утгын сургаалын хурал, 1941.
3. Түймэр улс байгуулагдахаас өмнөх Өвөр Монголын газар орны сонин сэтгүүлийг магадалсан гарчиг. Өвөр монголын номын сан. 1987.
4. *Се.Доржийн зохиолын түүвэр*. Хөх хот: Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2001.
5. “Улаан барс” сэтгүүлийн мэдэгдэл. Улаан барс, 1944. №4.
6. *Хээ Мэргэн, Хээшингэ*. Нэгэн хорчин монгол хүмүүн. Хөх хот: Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. 2001.

#### Резюме

Статья посвящена творческой, издательской и просветительской деятельности таких писателей Восточных монголов Внутренней Монголии Китая, как Бөххишиг, Эрдэнэтогтох, Манижав, Хээшингэ, Ролгоржав, Эрдэмтөгс и др. Автор, опираясь на исторические факты из разных источников, подробно рассказывает о большом вкладе вышеназванных писателей в основание и развитие периодической печати и издательского дела во Внутренней Монголии Китая.